



ХЭНТИЙ АЙМГИЙН  
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 19 өдөр

Дугаар 6/14

Бор-Өндөр сум

Албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр  
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5 дахь заалт, Засгийн газрын 2018 оны "Журам батлах тухай" 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт, 2024 оны "Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай" 82 дугаар тогтоол, "Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай" 84 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт, "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 128 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Бор-Өндөр Хот Тохижилт" орон нутгийн төсөвт үйлдвэрийн газрын дарга өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн тул тус үйлдвэрийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Алтанбаатарын Батчулууныг 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн томилсугай.

2. Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Х.Галбадрах

Бор-Өндөр сумын Засаг даргын орлогч

Гишүүд:

Э.Түвшинсайхан

ЗДТГ-ын Санхүүгийн албаны дарга

Б.Энхтуяа

"Бор-Өндөр Хот Тохижилт" ОНТУГ-ын  
Ерөнхий нягтлан бодогч

3. А.Батчулууны албан тушаалын үндсэн цалинг ТҮ-10 зэрэглэлийн 1,543,000 (нэг сая таван зуун дөчин гурван мянга) төгрөгөөр тогтоож, ур чадварын нэмэгдлийг үндсэн цалингийн 25 хувиар, орон нутагт ажилласны нэмэгдлийг үндсэн цалингийн 40 хувиар тус тус тооцон сар бүр бодож олгохыг тус үйлдвэрийн газрын Ерөнхий нягтлан бодогч (Б.Энхтуяа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Г.АДЪЯАБИЛЭГТ

